
Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,948,109.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 49,481.1 мянган төгрөгөөр тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Архивын ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 723,315.8 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 66,443.6 | 52,655.1 | (13,788.5) |
| Авлага | 400.0 | - | (400.0) |
| Бараа материал | 269,955.7 | 243,506.9 | (26,448.8) |
| Үндсэн хөрөнгө | 14,764,706.6 | 14,082,028.1 | (682,678.5) |
| **Нийт хөрөнгө** | **15,101,505.9** | **14,378,190.1** | **(723,315.8)** |
| Засгийн газрын хувь оролцоо | 2,503,228.1 | 2,503,228.1 | - |
| Дахин үнэлгээний зөрүү | 1,962,233.2 | 1,962,233.2 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 10,636,044.6 | 9,912,728.8 | (723,315.8) |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **15,101,505.9** | **14,378,190.1** | **(723,315.8)** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгө бөгөөд тайлант онд өмнөх оны үлдэгдээс зарцуулсан 13,788.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Бичиг хэргийн материал 2022 онд явагдах архив, албан хэрэг хөтлөлтийн анхан болон мэргэшүүлэх сургалтанд тараагдах гарын авлага материал хэвлүүлсэнтэй холбоотойгоор 17,800.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, аж ахуйн материалын эхний үлдэгдлээс цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийн 44,700.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотойгоор бараа материал данс 26,448.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс тайлант онд худалдаж авсан нийт 189,789.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-1/2178 тоот шийдвэрээр акталсан хөрөнгийн 126,359.3 мянган төгрөгийн дүнгээр хасагдсан бөгөөд элэгдэл, хорогдлын зардал 746,108.2 мянган төгрөг байгаа нь 682,678.5 мянган төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Тусламж, санхүүжилтийн орлого | 3,820,381.1 | 3,393,395.6 | (426,985.5) |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 52,600.0 | 19,359.7 | (33,240.3) |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 600,804.6 | 567,664.0 | (33,140.6) |
| **Үйл ажиллагааны орлого** | **4,473,785.7** | **3,980,419.3** | **(493,366.4)** |
| Цалин, шимтгэлийн зардал | 2,795,292.4 | 2,645,518.5 | (149,773.9) |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 470,968.4 | 441,161.5 | (29,806.9) |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 440,878.4 | 276,156.0 | (164,722.4) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 886,489.3 | 944,787.7 | 58,298.4 |
| Хөрөнгө шилжүүлсэн | 354,480.9 | 257,321.4 | (97,159.5) |
| Хөрөнгийн зардал | - | 138,790.1 | 138,790.1 |
| **Үйл ажиллагааны зардал** | **4,948,109.4** | **4,703,735.2** | **(244,374.2)** |

Үндсэн үйл ажиллагааны орлого, зардлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал санхүүжилтийн орлого буурснаас шалгаалан орлого 493,366.4 мянган төгрөгөөр буурсан, цалингийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал тус тус буурсан нь үйл ажиллагааны зардал 244,374.2 мянган төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Архивын ерөнхий газар 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 4,113,041.2 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 3,813,041.2 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 300,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас нийт төсвийг 220,626.5 мянган төгрөгөөр бууруулан 3,592,414.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд улсын төсвөөс 3,312,414.7 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 280,000.0 мянган төгрөг бүрдүүлж санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,294,747.8 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, төлөвлөснөөс 17,666.9 мянган төгрөг дутуу санхүүжилт орсон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 375,960.2 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 95,960.2 мянган төгрөгөөр давсан нь лавлагаа авах үйлчлүүлэгчийн тоо, давтамж нэмэгдсэнээс шалтгаалжээ.

ХЗДХЯ-с 262,550.1 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилт олгогдож, барилгын их засварт зарцуулсан байна.

Давсан орлогоос Сангийн сайдын 2021 оны 217 дугаар тушаалын дагуу 19,359.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, байгууллагад шаардлагатай байгаа хөрөнгө худалдан авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны давсан орлого болон санхүүжилтийн дутуу зарцуулалт нийт 179,536.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Урсгал зардлын гүйцэтгэл 3,491,191.8 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 64,913.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний урсгал зардлыг 14,918.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 475.4 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 20,364.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хөрөнгийн санхүүжилт 262,550.1 мянган төгрөг олгогдож, барилгын их засварт 138,790.1 мянган төгрөг, гараашийн барилгын өргөтгөлд 123,760.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

*Хүснэгт 3.* Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | **70411** | **Төрийн архив, албан хэрэг хөтлөлт** | **3,592,414.7** | **3,491,191.8** | **(101,222.9)** | **97.2%** |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 3,498,661.9 | 3,418,427.1 | (71,234.8) | 97.96% |
| 1.2 | 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 367.4 | 280.0 | (87.4) | 76.21% |
| 1.3 | 80215 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зардал | 8,500.0 | 8,500.0 | - | 100% |
| 1.4 | 80509 | ОУ-н байгууллагын гишүүнчлэл, хураамж | 5,387.0 | 4,850.9 | (536.1) | 90.05% |
| 1.5 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 79,498.4 | 59,133.8 | (20,364.6) | 74,38% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд tender.gov.mn цахим системээр худалдан авалтыг зохион байгуулж хэвлэлийн цаас /Багц-1/ худалдан авалтын төлбөрт 31,528.0 мянган төгрөг, хувилагчийн хор /Багц-2/ худалдан авалтын төлбөрт 9,840.0 мянган төгрөгийг “Хул консалтинг групп” ХХК-д шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Архивын ерөнхий газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архивын ерөнхий газар 2021 онд нийт 6,194,647.9 мянган төгрөгийн 223 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5,858.3 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлын батлагдсан төсөвт 10-аас доошгүй хувийн хэмнэлт, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт буюу 140.2 сая төгрөгийн хэмнэлт гаргах чиглэлийн дагуу хэмнэлт үүсгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг дахин давтахгүй байх, харьяалах дээд байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг биелүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх

2. Сангийн яамны 2020 оны 12-1/1987 тоот албан бичгээр Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-д “энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна.”, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар

баталсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавих шаардлага, шалгуур журам"-ын 2.1.5 "Шууд захирагч нарын ахлах нягтлан бодогч нь нягтлан бодогчоор 2-оос доошгүй жил ажилласан бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх" гэсэн заалтын дагуу Х.Цогтбаатарыг ахлах нягтлан бодогчоор томилон ажиллуулах саналыг ирүүлснийг Архивын ерөнхий газрын даргын 2020 оны Б/58 тоот тушаалаар Санхүү, аж ахуйн хэлтсийн даргаар томилсон байна. Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтод Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан үүргийг тусгаагүй байгаа нь холбогдох үүрэг хариуцлагын биелэлт, аливаа зөвшөөрөл олгох ба хянах тоголцоо нь эрх мэдлийн хуваарилалттай уялдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах талаар зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, төсвийн гүйцэтгэл нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалттай, Санхүү аж ахуйн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, нийт 25,151.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлсэн бөгөөд жилийн эцэст илрүүлсэн зөрчлөөс 13,038.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж арилгасан ба бусад алдаа, зөрчлийг аудитын илрүүлэлтэд нэмж тусгасан болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 633.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 55.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 4.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 1.9 | 2 | 1.9 | - | - | 100.0 |
| Албан шаардлага | 3 | 633.4 | 3 | 633.4 | - | - | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 55.9 | 1 | 55.9 | - | - | 100.0 |
| **Нийт дүн** | **7** | **691.2** | **7** | **691.2** | **-** | **-** | **-** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 38,096.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 28,588.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 6,073.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 3,435.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 4 алдаа, зөрчлийн дүн 15,366.4 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 49,481.1 мянган төгрөгөөс хэтрээгүй байгаа тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн тооцооллыг давтан хийж 28,588.4 мянган төгрөгийн зөрүүг залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Улаанбаатар Төмөр зам ХНН-ийн төрөлжсөн архивт гэрээт ажилтан ажиллуулахаар орон тоо, цалингийн санг Архивын ерөнхий газрын төсөвт тусгуулан батлуулж 8,314.2 мянган төгрөгийн санхүүжилтийг Улаанбаатар Төмөр зам ХХН-т олгосноос ажилтны ажлын үр дүнгээр тооцон 6,813.8 мянган төгрөгийн цалин, ажил олгогчийн төлөх НДШ-д 906.3 мянган төгрөгийг олгож, зарцуулаагүй үлдсэн 591.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь: </u> Буцаан төвлөрүүлээгүй 591.2 мянган төгрөгийг УБТЗ-аас суутган тооцох, төлбөрийн акт тогтоох.

Төрийн архивын нэр бүхий 6 ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо үндсэн цалингийн дунджийг буруу тооцож 5,481.9 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 174 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн архивын ажилтанд мөнгөн урамшуулал олгох журам”, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55-р тушаалын хавсралтаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь: </u> Илүү олгосон 5,481.9 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаас суутган тооцож, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Анхан шатны баримттай холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт:</u>*

Бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ 3,435.0 мянган төгрөгийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй, татварын цахим системд баталгаажуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.5 “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалттай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрд нь хянаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | АЕГ | АХГ-2022/332/ НА-СТА-ТШЗ | Байгууллагын даргын 2021 оны А/82 тоот тушаалаар биет болон биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээг тогтоосон боловч хуримтлагдсан элэгдлийн тооцоолол зөрүүтэй байна. | СБТ, СҮДТ, ӨӨТ-ийн тайлант үеийг залруулсан | 1 | 28,588.4 | 1 | 28,588.4 | | | | | | | | |
| 2 | АЕГ | АХГ-2022/332/ НА-СТА-ТШЗ | Улаанбаатар Төмөр зам ХНН-ийн төрөлжсөн архивт гэрээт ажилтан ажиллуулахаар орон тоо, цалингийн санг Архивын ерөнхий газрын төсөвт тусгуулан батлуулж 8,314,192.0 төгрөгийн санхүүжилтийг Улаанбаатар Төмөр зам ХНН-т олгосноос ажилтны ажлын үр дүнгээр тооцон 6,813,764.0 төгрөгийн цалин, ажил олгогчийн төлөх НДШ-д 906,320.7 төгрөгийг олго, зарцуулаагүй үлдсэн 591,196.3 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна. | Буцаан төвлөрүүлээгүй 591,196.0 төгрөгийг УБТЗ-аас суутган тооцох төлбөрийн акт тогтоох. | 1 | 591.2 | | | 1 | 591.2 | | | | | | |
| 3 | АЕГ | АХГ-2022/332/ НА-СТА-ТШЗ | Төрийн архивын нэр бүхий 6 ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо үндсэн цалингийн дундажийг буруу тооцож 5,481,920.98 төгрөг илүү олгосон байна. | Илүү олгосон 5,481,920.98 төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаас суутган тооцож, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох. | 1 | 5,481.9 | | | 1 | 5481.9 | | | | | | |
| 5 | АЕГ | АХГ-2022/332/ НА-СТА-ТШЗ | Мөнгөн хөрөнгийн зарим зарлагын гүйлгээг татварын цахим систем дэх И-баримтаар баталгаажуулаагүй байна. | Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүр хянаж ажиллах. | 1 | 3,435.0 | | | | | | | | | 1 | 3,435.0 |
| Дүн | | | | | 4 | 38,096.5 | 1 | 28,588.4 | 2 | 6,073.1 | | | | | 1 | 3,435.0 |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | АЕГ | АХГ-2022/332/НА-СТА-ТШЗ | Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 5,858.3 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан байна.. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх | 1 | 5,858.3 | | | | | 1 | 5,858.3 | | | | |
| | | | Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлын батлагдсан төсөвт 10-аас доошгүй хувийн хэмнэлт, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт буюу 140,208.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргах чиглэлийн дагуу хэмнэлт үүсгээгүй байна. | Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, харьяалах дээд байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийг биелүүлж ажиллах албан шаардлага өгөх. | 1 | 140,208.4 | | | | | 1 | 140,208.4 | | | | |
| 2 | АЕГ | АХГ-20220/332/НА-СТА-ТШЗ | Төсвийн тухай хуулийн 19.3 “энэ хуулийн 19.1, 19.2-т зааснаас бусад тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлан нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна”, Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 28-ны өдрийн 294-р тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлан нягтлан бодогчид тавих шаардлага, шалгуур журам”-ын 2.1.5 “Шууд захирагч нарын ахлан нягтлан бодогч нь нягтлан бодогчоор 2-оом доошгүй жил ажилласан бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх” гэсэн заалтын дагуу Х.Цогтбаатарыг ахлах нягтлан бодогчоор томилон ажиллуулах саналыг Сангийн яамны 2020 оны 12-1/1987 тоот албан бичгээр ирүүлснийг Архивын ерөнхий газрын даргын 2020 оны Б/58 тоот тушаалаар Санхүү, аж ахуйн хэлтсийн даргаар томилсон байна. Санхүү, аж ахуйн хэлстийн даргын ажлын байрны тодорхойлолтонд Нягтлан бодох бүртгэлийн тухай | СААХ-н даргын ажлын байрны тодорхойлолтод хуульд заасан үүргүүдийг тодорхой тусгаж шинэчилэн боловсруулах зөвлөмж өгөх. | 1 | - | | | | | | | | | 1 | - |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуулийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасан үүргийг тусгаагүй байгаа нь холбогдох үүрэг хариуцлагын биелэлт, аливаа зөвшөөрөл олгох ба хянах тогтолцоо нь эрх мэдлийн хуваарилалттай уялдахгүй байна. | | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | 2 | 146,138.7 | | | | | 2 | 146,138.7 | | | 1 | 0 |
| Нийт дүн | | | | | 7 | 184,235.2 | 1.0 | 28,588.4 | 2.0 | 6,073.1 | 2 | 146,138.7 | | | 2 | 3,435.0 |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2022 оны 02 дугаар сарын 25 № 03/А0150055 Улаанбаатар хот
АХГ-2022/332/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн архивын нэр бүхий 6 ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо үндсэн цалингийн дунджийг буруу тооцоолж, 5,481,920.98 төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 174 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн архивын ажилтанд мөнгөн урамшуулал олгох журам", Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-тай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 5,481,920.98 төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаас суутган тооцож, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ

ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХТӨР

9006109
9019120596

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0224 Auditin 2 Gazar-2.Docx

001090002

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2022 оны 02 дугаар сарын 25 № 02/А0150055 Улаанбаатар хот

АХГ- 2022/332/ НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаанбаатар Төмөр зам ХНН-ийн төрөлжсөн архивд гэрээт ажилтан ажиллуулахаар орон тоо, цалингийн санг Архивын ерөнхий газрын төсөвт тусгуулан батлуулж 8,314,192.00 төгрөгийн санхүүжилтийг Улаанбаатар Төмөр зам ХНН-т олгосноос ажилтны ажлын үр дүнгээр тооцон 6,813,764.00 төгрөгийн цалин, ажил олгогчийн төлөх НДШ-д 906,320.70 төгрөгийг олгож, зарцуулаагүй 591,196.30 төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Буцаан төвлөрүүлээгүй 591,196.30 төгрөгийг Улаанбаатар Төмөр зам ХНН-аас суутган тооцож Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХТӨР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0224 Auditin 2 Gazar-3.Docx

7001090004

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 06/А0150055 Улаанбаатар хот
АХГ-2022/33Q/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр 140,208,410.96 сая төгрөгийн төсвийг хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.1"үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дунд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.8 "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын шийдвэрийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХТӨР

9006109
9019120396

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 04/А0150055 Улаанбаатар хот
АХГ-2022/330/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Архивын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 5,858,277.63 төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *“Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, санхүү аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| ИНГҮҮМЭЛ ЖАРГАЛАНТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Г.ЭНХТӨР |

9006109
9019120396

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ